# "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК
## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

2025 оны 04 сарын 21 өдөр № 01 Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.9 дэх заалт, 2025 оны 04 дүгээр сарын 21–ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Д.ТОГТОХБАЯР

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

2025 оны 04 сарын 21 өдөр №02 Улаанбаатар хот

**“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.14 дэх заалт, 2025 оны 4 дүгээр сарын 21–ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Тогтохбаяр)-д тус тус даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА** **Д.ТОГТОХБАЯР**

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
БИРЖ ХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9023070390 2071096
УЛААНБААТАР ХОТ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 04 дүгээр сарын 21 ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

ХӨРӨНГИЙН БИРЖ ХК
STOCK EXCHANGE
9023070390 ✓ 2071096
УЛААНБААТАР ХОТ

# "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН 2025 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ САНАЛ

**(мян.төгрөг)**

| № | Үзүүлэлтүүд | 2023 оны гүйцэтгэл | 2024 он | | 2025 оны төлөвлөгөө | 2024 оны гүйцэтгэлтэй харьцуулсан өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тодотгосон төлөвлөгөө | Хүлээгдэж буй гүйцэтгэл* | | хувь | Дүн |
| **1** | **Нийт орлого:** | **16,722,642** | **37,076,055** | **45,367,995** | **42,693,290** | **-6%** | **-2,674,705** |
| **1.1** | *Үнэт цаасны арилжааны шимтгэл* | 2,598,470 | 3,147,318 | 3,074,369 | 3,520,887 | 15% | 446,518 |
| **1.2** | *УУББ-ийн арилжааны шимтгэл* | 6,855,221 | 8,054,350 | 7,937,458 | 6,008,888 | -24% | -1,928,570 |
| **1.3** | *Жилийн хураамж, үйлчилгээний хөлс* | 2,589,850 | 1,736,651 | 1,733,135 | 1,625,597 | -6% | -107,538 |
| **1.4** | *Хүүгийн орлого* | 4,562,440 | 24,014,336 | 32,531,024 | 31,406,008 | -3% | -1,125,016 |
| **1.5** | *Бусад* | 116,661 | 123,400 | 92,009 | 131,909 | 43% | 39,900 |
| **2** | **Нийт зардал:** | **6,198,409** | **9,840,413** | **8,735,119** | **11,085,530** | **27%** | **2,350,411** |
| **2.1** | Үйл ажиллагааны зардал | 3,710,301 | 6,644,509 | 5,917,023 | 7,842,283 | 33% | 1,925,260 |
| **2.2** | Удирдлагын зардал | 152,809 | 442,354 | 226,692 | 544,406 | 140% | 317,714 |
| **2.3** | ҮХ элэгдлийн зардал | 609,066 | 900,532 | 900,532 | 978,182 | 9% | 77,650 |
| **2.4** | Арилжааны систем ашиглалтын зардал | 1,726,233 | 1,853,017 | 1,690,872 | 1,720,660 | 2% | 29,788 |
| **3** | **Татварын өмнөх цэвэр орлого /алдагдал/** | **769,748** | **27,031,225** | **36,428,458** | **31,403,342** | **-14%** | **-5,025,116** |
| **4** | Орлогын, хүүгийн орлогын татвар | 123,520 | 834,958 | 3,663,288 | 3,140,601 | -14% | -522,687 |
| **5** | **Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/** | **646,228** | **26,196,267** | **32,765,171** | **28,262,742** | **-13.7%** | **-4,502,429** |
| **6** | Нийт авлага /цэвэр/ | 1,868,455 | 250,092 | 674,334.0 | 201,900 | | (450,001) |
| **7** | Нийт өглөг /системийн зардал оруулж тооцсоноор/ | 2,252,254 | 848,455 | 1,031,617 | 807,752 | | (223,865) |
| | УУББ-ийн арилжааны дэнчингийн мөнгө | 880,962,845 | 881,747,146 | 1,021,207,267 | 893,556,358 | | (127,650,908) |
| **8** | Ажиллагсдын тоо | 53 | 72 | 72 | 72 | | - |
| **9** | Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал | 0.37 | 0.27 | 0.19 | 0.26 | | 0.07 |
| **10** | Хөрөнгө оруулалт | 557,807 | 6,536,954 | 4,638,456 | 4,862,880 | | 224,424 |

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

2025 оны 04 сарын 21 өдөр №03 Улаанбаатар хот

**Компанийн үндсэн үйл ажиллагаанд ашигладаг системийн талаар авах зарим арга хэмжээний тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.15, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 21–ний өдрийн ээлжит хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл, Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд ашигладаг үнэт цаасны арилжааны болон уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Тогтохбаяр)-д зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Д.ТОГТОХБАЯР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9023070390 № 2071096
УЛААНБААТАР ХОТ

**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

2025 оны 04 сарын 21 өдөр №04 Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг тогтоох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.13, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний сарын үндсэн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тус тус тогтоосугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны хуралд оролцсон сар бүр үндсэн цалингийн 25 хувьтай тэнцүү хэмжээний нэмэгдлийг тооцож олгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний сарын цалин хөлсийг тэдгээрийн хуралд оролцсон ирцийг үндэслэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА** **Д.ТОГТОХБАЯР**

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 04 сарын 21 өдөр | №05 | Улаанбаатар хот

**Хяналтын зөвлөлийн гишүүдийг**
**сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь хэсэг, компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 2025 оны 04 дүгээр сарын 21–ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2027 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаатайгаар сонгосугай. Үүнд:

   Хяналтын зөвлөлийн гишүүн: Д.Ганзориг
   Хяналтын зөвлөлийн гишүүн: Ж.Ариунгэрэл
   Хяналтын зөвлөлийн гишүүн: С.Хулан

2. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүний урамшууллын хэмжээг хуралд оролцсон сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор сонгогдсон Хяналтын зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосугай.

4. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүний урамшууллыг тэдгээрийн хуралд оролцсон ирцийг үндэслэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналтын зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА** **Д.ТОГТОХБАЯР**